



ЗӨВЛӨМЖ

#1. ЗӨВЛӨМЖ

Хуульд эрх хэмжээ олгоогүй байхад захиргааны хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлж, иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг журамлах, төлбөр хураамж тогтоох зэрэг зөрчил нийтлэг гарч байгааг таслан зогсоож арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх.

Дархан-Уул аймгийн ИТХ, ЗДТГ болон Шарын-гол суманд ажиллахад хуулиар захиргааны хэм хэмжээний акт тогтоох эсвэл тухайн асуудлыг шийдвэрлэх эрх олгогдоогүй байхад хэм хэмжээний акт гаргасан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлбэл зохих хэм хэмжээний актыг бүртгүүлэхгүй дагаж мөрдүүлсэн, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй зохицуулалт тусгасан, хуулиас давсан шаардлага тогтоосон, хууль бус төлбөр хураамж, торгууль бий болгосон, мөн захиргааны актад хуулийн холбогдох заалтыг дурьдаагүй, шинэчлэн найруулагдсан болон хүчингүй болсон хууль /Засгийн газрын тогтоол, сайдын тушаал/-ийг үндэслэсэн дүрэм журам батлан мөрдүүлэх зөрчил илэрсэн болно. Тухайлбал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.д-д: “хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг ИТХ-д олгосон байхад дээрх заалтыг зөрчин ИТХТ-д өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргасан, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг зөрчсөн, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх шаардлагыг хангаагүй Булган аймгийн ИТХТ-ээс баталсан 6 дүрэм журам, Шарын-гол сумын ИТХТ-ээс баталсан 2 дүрэм журам байсан бөгөөд дээрх дүрэм журмыг хүчингүй болгон хууль тогтоомжид нийцүүлэн батлах, дахин ийм зөрчил гаргахгүй байхад анхааран ажиллах нь зүйтэй. (Хавсралт 1)



Дархан-Уул аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын байдлыг хянан үзэхэд 2017 онд Буцалтгүй тусламж, тэтгэмж, шагнал, урамшууллын зардалд 19.851.000 төгрөг буюу 4.2 хувь, Байгалийн гамшиг, осол, үр дагаврыг арилгах зардалд 110.611.155 төгрөг буюу 23.2 хувь, гоц халдварт өвчний голомтыг арилгах 30.900.556 төгрөг буюу 6.5 хувийг, цэрэг татлага, дүйцүүлэх албаны зардалд 5.793.000 төгрөг буюу 1.2 хувь, мал тооллогод 1.574.300 төгрөг буюу 0.3 хувь, Зорилт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 94.325.249 төгрөг буюу 19.8 хувь, нөхөн олговорт 20.000.000 төгрөг буюу 4.2 хувь, түрээсийн зардалд /УИХ-ын гишүүний албан ерөөний түрээс/ 4.175.500 төгрөг буюу 0.9 хувийг, 2018 оны 10 сарын байдлаар зорилт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 39.583.655 төгрөг буюу 20.7 хувь, Цэрэг татлагын зардалд 9.581.980 төгрөг буюу 5.0 хувь, УИХ-ын бие төлөөлөгчийн албан ерөөний түрээсийн зардалд 2.982.500 төгрөг буюу 1.6 хувь буюу 2017 онд нөөц хөрөнгийн 60.3 хувийг, 2018 оны 10 сарын байдлаар 57 хувийг тус тус зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр журмын 2.3 дахь хэсэг буюу “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэнтэй нийцэж байна.

Харин Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр журмын 5.1 “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж, цэргийн штабын хээрийн сургуулийн төвийн контейнер буюу чингэлэг худалдан авахад 4.000.000 төгрөг, УИХ-ын бие төлөөлөгчийн албан ерөөний түрээсийн зардалд 2.982.500 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжилт хийсэн нь дээрх журамд нийцэхгүй байх тул цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээ нь жил бүр улсын хэмжээнд болдог урьдчилан төлөвлөж, төсвийн үрсгал санхүүжилтэд тусган шийдвэрлэх боломжтой асуудал гэдгийг анхаарч ажиллах нь зүйтэй.

#2. ЗӨВЛӨМЖ

Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ажиллах, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй байдалд тавих хяналтыг сайжруулах.



Хэдийгээр Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалтуудыг зохион байгуулж гүйцэтгэлийг тооцон ажилласан боловч Сангийн сайдын 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хэрэгжилт үр дүн муутай байдал ажиглагдаж байна.

“Дархан сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн хүрээнд хийгдэх 60 айлын орон сууцны барилга угсралтын ажил” Захиалагч нь зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж 2 удаагийн тендер шалгаруулалтанд тэнцээгүй компанийг сонгон гэрээ байгуулсан төдийгүй гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлийн баримтыг үндэслэн 1 257 914 000 төгрөгийн санхүүжилтийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, мөн ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй нөхцөл байдлыг бий болгосон байна.

#3. ЗӨВЛӨМЖ

ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байх, ижил төстэй төсөл арга хэмжээг нэгтгэн багцалж төлөвлөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх.



#4. ЗӨВЛӨМЖ

Төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг бодитоор тооцсоны үндсэн дээр хуулиар тогтоосон хугацаанд төлөвлөж батлуулах, төсөл арга хэмээний хэрэгжилтэнд дотоод хяналтыг сайжруулах, Ашиглалтанд хүлээлгэн өгөх гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож явцын хяналтыг сайжруулах, Төсөл арга хэмжээний худалдан авалтын аргыг оновчтой зөв хэрэглэх.

ДУАОНӨГ/201803056 дугаартай Эрчимжсэн мал аж ахуй суурьшлын бүс шинээр байгуулах дэд бүтэц татах ажлын сонгон шалгаруулалтанд Хатуу төмөр ХХКомпани шалгарч захиалагчтай 2018.09.27 –ны өдрийн 2018-01/35 тоот 230 100 074 төгрөгийн санхүүжилт бүхий гэрээ байгуулсан боловч гэрээний дагуу ажил эхлээгүй, ажлын гүйцэтгэлийн баримт гараагүй бөгөөд гэрээний хугацаа дуусах болсон байна. Энэ ажил нь анхнаасаа суурьшлын бүсийг байгуулах газрын судалгааг гаргаагүй улмаас энэ онд хэрэгжих боломжгүй болсон байна.

Дархан сум 12 дугаар багийн нутаг дэвсгэр дэхь 27 дугаар байрны дундах автозамыг хэсэгчилж засварлах, төв авто замтай холбосон гарцны засврын ажил Татварын өртэй байгууллагыг шалгаруулж гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т “МУ-ын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг зөрчсөн. Гэтэл зарим төсөл арга хэмжээний худалдан авалтыг харахад татварын өртэй гэсэн үндэслэлээр худалдан авах ажиллагааг хүчингүй болгосон байна.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 11/01 тоот тогтоолоор 2018 оны тодотгосон төсвөөр орон нутгийн төсвийн 450.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлуудыг яаралтай эхлүүлэх, ажлыг эрчимжүүлэх асуудлыг хэлэлцэж тендер зарласан боловч оролцогч ирээгүй 138649.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай 5 ажил, улсын төсвийн 107.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай 1 ажил, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 1 179 289.9 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай 1 ажилд шууд гэрээ байгуулах эрх олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчсөн.

Дархан сумын Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд “Хүүхэд залуучуудын соёл, амралтын цогцолбор” байгуулах ажлын хүрээнд хөдөлгөөнт тоглоом, материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу цахимаар зарлаж явуулахад “Ти Эс Жи” ХХКомпани материалаа ирүүлсэн боловч ирүүлсэн тендер нь тендерийн баримт бичгийн шаардлага хангахгүй байсан тул үнэлгээний хороо татгалзсан байна. Үнэлгээний хороо нь захиалагчид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмж гаргаж 2018.06.15-ны өдрийн 368-1 тоотойр аймгийн ХОХБТХэлтэст хүргүүлэхэд “Ти Эс Жи” компанитай 1 180 052 846 төгрөгийн үнийн саналтай гэрээг байгуулсан байна.

Үнэлгээний хороо нь тендерт оролцогчийн материалыг хянан үзээд оролцогч компани нь тендерт шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардсан шаардлагуудыг дутуу ирүүлсэн, ирүүлсэн бичиг баримт нь шаардлага хангахгүй байгаа тул/ нийт 11 шалгуур үзүүлэлт шаардлага хангаагүй байна/ бүх тендерээс татгалзахыг гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэжээ. Гэвч Үнэлгээний хороо нь тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нөхцлийг судлан дахин тендер шалгаруулалт явуулах эсэхийг шийдвэрлэхгүйгээр бүх тендерээс татгалзаж захиалагчид шууд гэрээ байгуулахыг зөвлөсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэхь заалт, 30.4.2 дахь заалтыг зөрчсөн.



#5. ЗӨВЛӨМЖ

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтлах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлж байгаад онцгой анхаарах, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх.

Нөгөө талаар Захиалагч нь зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэхдээ эхний тендер шалгаруулалтанд тэнцээгүй компанид урилга хүргүүлэн улмаар сонгон шалгаруулж гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчжээ.

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд, захиалагч талын ажилтнууд нь хуульд нийцүүлэн ажиллаагүйгээс тухайн шалгарсан компанид ямар нэг байдлаар давуу байдал олгосон бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэхь заалт, 50.1.2 дахь заалт 50.1.3 дахь заалтыг зөрчсөн үйлдлийг гаргасан байж болзошгүй байна.

Хяналтаар тендерт шалгарсан компанид давуу байдал олгосон, холбогдох хуулийн заалтыг / Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн/ заалтыг зөрчсөн нөхцөл байдал тогтоогдвол тухайн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх.



Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> - ээс татаж үзэх).

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөн ажиллах шаардлагатай.

#6. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.



#7. ЗӨВЛӨМЖ

Албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй. Гэтэл тус аймгийн хэмжээнд 2017 оны 09 дүгээр сараас 2018 оны 9 дүгээр сарын байдлаар томилогдсон 3 албан тушаалтан дээр дурдсан үүргээ биелүүлээгүй буюу томилогдсон өдрөөс хойш хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна. (Хавсралт 2).

Дээр дурдсан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д заасны дагуу тухайн албан тушаалд томилогдсоноос хойш хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хоцроосон тул сануулах” шийтгэлийг тус тус ногдуулсан.



Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлдөг зөрчил тус аймгийн боловсролын салбарт арилахгүй байна. Тухайлбал, Сүүлийн 2 жилийн хугацаанд Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлыг 4 удаа, 6 сургуулийн захирлыг 5 удаа, 15 дугаар сургуулийн захирлыг 4 удаа, 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийг 2 удаа, 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийг 3 удаа тус тус өөрчлөн томилжээ.

Ажлаас үндэслэлгүй халагдсан, чөлөөлөгдсөн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг захиргааны байгууллагаас нөхөн төлж төсвийг үр дүнгүй зарцуулж, хохирол учруулж байгаа учраас хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирлыг буцааж төлүүлж барагдуулах талаар арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ. Хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “...гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

#8. ЗӨВЛӨМЖ

Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохдоо мерит зарчмыг удирдлага болгох, албан тушаалаас чөлөөлөхтэй холбогдуулан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх.